

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГ ГАВИЛУЙ УУЛЫН ДУРСГАЛТ ГАЗАРТ ЯУВУУЛСАН “СЯНЬБИГИЙН ҮЕИЙН ХААД ЯЗГУУРТНЫ БУНХАНТ БУЛШНЫ СУДАЛГАА” ТӨСЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН 2023 ОНЫ ТАЙЛАН

МУИС-ийн Улаанбаатар сургуулийн Түүх, археологийн тэнхимийн профессорын II баг Гавилуй уулын Сяньбигийн үеийн бунхант булшны малтлага судалгааны ажлыг Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр 2023 оны 06-р сарын 24-ний өдрөөс 08-р сарын 07-ний өдөр хүртэл 45 хоногийн хугацаанд ажиллаж Монголын эртний түүх, тэр дундаа Сяньбигийн үеийн түүхэнд нээлтэд тооцогдох томоохон судалгааны ажлыг амжилттай гүйцэтгээд байна. Энэ жил Гавилуй уулын дурсгалт газарт хэмжээгээрээ хамгийн томд тооцогдох 7 болон 9 дугаартай 2 бунхант булшийг сонгон авч малтан судалгааны ажлыг эхлүүлсэн юм.



Бунхант булш нь баруун хойш харсан үүдэвчтэй, бунхныг тойрсон усан татаал шуудуу нь гүн хэсэгтээ 2 м бөгөөд шуудууны хоёр үзүүрийн төгсгөлд тавьсан тахилын шинжтэй олдворуудтай байгаа нь сонирхолтой бөгөөд бунхны үүдэвчийг огцом доош 2,2 м гүн ухаж модон шатыг доош гулсаж гүйлгэхгүйн улмаар хос нүх ухсан ором гарсан байна. Энэ үеийн бунхны үүдэвчний шалан дээр 5 үхэр, 1 адуугаар зүлд тахилга нь маш эртний уламжлалыг хадгалсан байх бөгөөд энэхүү зан үйлийг хүрэл зэвсгийн дунд үеэс буюу одоогоос 3000 жилийн тэртээ Монгол нутаг дээр өөрсдийн төрт улсыг байгуулж байсан буган хөшөөт хиргисүүрийн соёлынхны гол ялгарах онцлог бүхий тахилгыг үйлдсэн явдал сяньбичүүд

өнөөгийн Монгол нутаг дээр 3000 жилийн тэртээ байсан нүүдэлчин өвөг овгийн уламжлалыг хадгалсан, цаашид хөгжүүлэн өвлөж байсныг гэрчлэх чухал түүхэн баримт боллоо. 2 бунхант булшнаас хүн, малын яснаас гадна шавар ваарны хагархай, ясан эдлэл зэрэг нийт 49 ширхэг эд өлгийн зүйл олдвор илэрч олдсон болно.

